




СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

“Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага”
Түргэвчилсэн судалгаа

2022 оны 9-р сараас 2023 оны 2 дугаар сар
(Гурав дугаар ээлжийн тоон мэдээлэл нэгтгэл)



Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

© ОДБАЯР

АГУУЛГА

Удиртгал ба аргачлал.....	1
1. Мэдээллийн дүн шинжилгээ – Сонгинохайрхан дүүрэг	4
1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм	4
1.2 Бүртгэл.....	5
1.3 Ирсэн иргэд.....	6
1.4 Явсан иргэд.....	8
1.5 Хөдөлмөр эрхлэлт	9
1.6 Санхүүгийн нөхцөл байдал	10
1.7 Шижилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд.....	10
1.8 Үйлчилгээний хүртээмж ба дэд бүтэц.....	12
Дүгнэлт.....	13

УДИРТГАЛ БА АРГАЧЛАЛ

УДИРТГАЛ

Энэхүү дүүргийн хэмжээний тайлан нь Сонгинохайрхан дүүргийн хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход чиглэсэн үндсэн сэдвүүдийн хүрээнд 2022 оны 9 дүгээр сараас 2023 оны 2 дугаар сарын тойм мэдээллийг харуулсан болно. Уг судалгаа нь Монгол дахь ОУШХБ-аас Улаанбаатар хотод хийсэн хөдөлгөөнийг тандах ДТМ судалгааны аргачлалын гурав дахь удаагийн тоон мэдээлэл нэгтгэлийн үе шат юм.

Нэгдүгээр шатны тоон мэдээлэл нэгтгэлийн адил энэхүү судалгаагаар Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд хүн амын бодит тоон мэдээлэл, суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад (шилжилт хөдөлгөөн), хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц гэсэн найман үндсэн сэдвийг авч үзсэн болно. Тоон мэдээллийг Сонгинохайрхан дүүргийн хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн¹ нутаг дэвсгэрийн нөхцөл байдал, мэдээлэл нэгтгэгчийн мэдлэгийн нөөц бололцоо, мэдээллийн нээлттэй байдлаас хамааран хэсгийн ахлагч нараар тандалт судалгаа, ярилцлага хийх замаар нэгтгэсэн болно.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ)-ын өмнөх судалгаануудаас харахад газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг хүчин зүйлс Монгол Улсын уламжлалт амьдралын хэв маягийг өөрчилж байгааг бидний хийсэн өмнөх судалгаанууд тогтоосоор байна. Ган, зудын² давтамж нэмэгдэж, ажлын байр цөөн, амьдрах орчин нөхцөл хангалтгүй, хөдөөгийн хүн амын мал аж ахуйгаас хараат байдал зэрэг нь суурин газар болон бусад аймаг³ орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх хүчин зүйл болсоор байна.

Тэдгээр шилжих хөдөлгөөний үндсэн шинж чанарыг ойлгоход Монгол Улсын хэмжээнд өөр өөр байршилд ажиллаж амьдарч, шилжилт хөдөлгөөнд оролцож буй хүн амын бодит тоон мэдээлэл шаардагдах бөгөөд мэдээллийн зөрүүтэй байдал үндсэн шинж чанарыг ойлгоход саад болж байна. Энэхүү судалгаа нь Сонгинохайрхан дүүргийн хүн ам, шилжилт хөдөлгөөний бодит мэдээллийг олж авах замаар энэ хоёр мэдээлэл хоорондын зөрүүг арилгаж дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх бодлого, үйл ажиллагааг бодит мэдээллээр хангах, мэдээллийн баазыг нэмэгдүүлэх зорилготой.

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Энэхүү тайланд Монгол Улс дахь ОУШХБ-ын Шилжилт хөдөлгөөнийг тандах матриц (ДТМ)-ийн аргыг үндэслэн боловсруулсан хөдөлгөөнийг тандах (МТ) дэд аргачлалыг ашигласан болно.

Судалгаанд Сонгинохайрхан дүүргийн хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн түвшинд хэсгийн ахлагч нараар дамжуулан тоон мэдээллийг нэгтгэсэн. Хэсгийн ахлагч нар өөрийн нутаг дэвсгэрийн иргэдтэй ярилцах, ажиглалт хийх, өөрсдийн бусад нөөц бололцоог ашиглах болон харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан тоон мэдээллийг нягтлах, баталгаажуулах ажлыг хийсэн. Хэсгийн ахлагч нарыг судалгааны агуулга тус бүрээр нь ялган эрэмбэлсэн найман үндсэн сэдвийг багтаасан судалгааны агуулгыг/хэрэгслийг нөхөхийг хүссэн юм. Тэд Кобо программ хангамжаар дамжуулан тоон ажиглалт, баталгаажуулалт хийгдсэн мэдээллийг гар утас эсвэл таблет ашиглан цахим системд нөхөж илгээсэн. Мэдээллийг зөв, чанартай нэгтгэхийн тулд судалгааг хэрэгжүүлэхээс өмнө хэсгийн ахлагч нарыг судалгааны асуулгын дэлгэрэнгүйг ойлгох, тандалт судалгааг хийх арга аргачлалыг багтаасан сургалтад хамруулсан. Түүнчлэн ДТМ судалгааг

хариуцсан ажилтнууд мэдээлэл нэгтгэх явцад үүссэн аливаа асуулт, асуудалд цаг тухайд нь хариу өгч бэлэн байдалд ажилласан юм.

Өгөгдлийг системд нэгтгэх үйл явц албан ёсоор хаагдамагц ДТМ-ийн судалгааны баг бүрэлдэхүүн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн бөгөөд гарч болзошгүй алдаа, тоон мэдээллийн зөрүү, давхардал зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийн хяналтын шатанд чанарын баталгаажуулалтын шалгалтыг сонгогдсон дүүргүүд дээр хийсэн. Энэхүү тайланд тусгагдсан аливаа үр дүнг хэсгийн түвшинд нягтлан харах боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй юм.

ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

Энэхүү судалгаанд ашигласан аргачлал нь үндсэн мэдээлэгч нараас өгсөн мэдээлэлд дүн шинжилгээ


хийж байгаа төдийгүй бусад эх сурвалжтай гурвалсан өгөгдлийн санг бий болгох үндсэн зорилготой юм.

Нэгтгэсэн өгөгдөл нь үндсэн мэдээлэгч нарын мэдлэгт тулгуурласан ажиглалт, тооцоолол, төсөөллийг илэрхийлдгээрээ ялгаатай юм. Тиймээс өгөгдлийн найдвартай байдал нь ажиглалт, тандалт судалгааг хийж буй нэгжийн хэмжээ (жишээ нь, хэсгийн хэмжээ, хүн ам), хэсгийн ахлагчийн иргэдтэй хэр ойр холбоотой, ажиглалт, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвар, мэдлэг гэх мэт хүчин зүйлсээс хамаарч ялгаатай байх магадлалтай тул өгөгдлийн гадаад болон дотоод мэдээллийн хүчин төгөлдөр байдал хязгаарлагдмал юм.

Нэмж дурдахад, тоон мэдээллийн үр дүнгийн гурвалжинд тусгасан үнэлгээ нь тухайн ажиглалт хийсэн байршилд зөвхөн нэг гол мэдээлэгчээс авсан мэдээллээр хязгаарлагдсан болно.

ГАЗАР ЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Газрын зураг 1. Сонгинохайрхан дүүргийн газрын зураг (хороогоор)



Хүснэгт 1. Тоон мэдээлэл нэгтгэх үеийн Сонгинохайрхан дүүргийн хүн ам

Дүүрэг	Хэсгийн тоо	Хүн амын тоо (бүртгэлгүй түр оршин суугчдын мэдээллийг багтаасан)
Сонгинохайрхан	370	352,410
Нийт	370	352,410

НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Хүн амын суурь тоон үзүүлэлт: Гарал үүсэл, бичиг баримтын байдал, хууль эрх зүйн нөхцөл байдал, бүртгэл, нас, хүйс, нийгэм-хүн ам зүйн бусад шинж чанараас үл хамааран үнэлгээ хийх үед тухайн байршилд байгаа бүх оршин суугч.

Өрх: Нэг дээвэр дор амьдардаг, зардал болон хоол хүнсээ хуваалцдаг бүлэг хүмүүс.

Ирсэн иргэд: Улаанбаатар хот дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран хамгийн багадаа дөрвөн долоо хоног болон түүнээс дээш хугацаагаар оршин суух зорилготой хотын ямар нэг байршилд ирсэн хүмүүс (шилжилт хөдөлгөөн, түр оршин суух бүртгэл зэргийг хийлгэсэн эсэхээс үл хамаарна).

Явсан иргэд: Улаанбаатар хот дотор эсвэл хотын гадагшаа явсан эсэхээс үл хамааран хамгийн багадаа

дөрвөн долоо хоногийн туршид буцах бодолгүй, аль нэг байршилд явсан хүмүүс (шилжилт хөдөлгөөн, түр оршин суух бүртгэл зэргийг хийлгэсэн эсэхээс үл хамаарна).

Мэдээлэгч: Мэдээллийн эх сурвалж бөгөөд энэ судалгаанд Улаанбаатар хотын нийт хэсгийн ахлагч нарыг хэлнэ.

Мэдээлэл нэгтгэгч: Мэдээлэл нэгтгэж буй хүн. Энэхүү үнэлгээнд үндсэн мэдээлэгч нар мэдээлэл нэгтгэсэн тул эдгээр хоёр нэр томьёо давхцана.

Гэр хороолол болон орон сууц зонхилсон хэсэг: Засаг захиргааны хамгийн жижиг хэсэгт улсаас халаалт, цэвэр усаар хангагдсан орон сууц, зөөврийн усаар хэрэгцээгээ хангадаг, мод, нүүрс түлж гэрээ дулаацуулдаг гэр хороолол зэрэгцэн оршдог хэсгийг хэлнэ.

1. МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ - СОНГИНОХАЙРХАН

1.1 ХҮН АМЫН СУУРЬ ТООН ҮЗҮҮЛЭЛТ БА ХҮН АМ ЗҮЙН ТОЙМ



95,663

Өрх



352,410

Хувь хүн



52%

Эмэгтэй



35%

Хүүхэд



6,887

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн



2,600

Асран хамгаалагчгүй ахмад настан



2,287

Жирэмсэн эмэгтэй



3,775

Эцэг, эхийнхээ аль нэгээс тусгаарлагдсан хүүхэд



4,243


Өрх толгойлсон эцэг, эхтэй өрх



10,637

60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрх

График 1. Хүн ам зүй (ээлэх хувь насны бүлгээр)




Үнэлгээ хийх үед (хүрээнд 2022 оны 9 дүгээр сараас 2023 оны 2 дугаар саруудад) Сонгинохайрхан дүүрэгт 352,410 иргэн буюу 95,663 өрх бүртгэгдсэн нь Улаанбаатар хотын хүн амын 21 хувийг эзэлж байна. Дүүргийн хүн амын 52 хувь нь эмэгтэй байна. 35 хувь нь насанд хүрээгүй хүүхэд байгаа нь өндөр үзүүлэлт бөгөөд үүний 12 хувийг 0-5 нас, 23 хувийг 6-17 насны хүүхдүүд эзэлж байна. Хүн амын 56 хувийг 18-59 насны насанд хүрэгчид, 9 хувийг 60 болон түүнээс дээш насны ахмад настан эзэлж байна.

Сонгинохайрхан дүүрэгт нийтдээ 6,887 хөгжлийн бэрхшээлтэй иргэн (дүүргийн хүн амын 2 хувь), 2,287 эмэгтэй жирэмсэн (эмэгтэйчүүдийн 1 хувь), 2,600 асран хамгаалагчгүй ахмад настан (60 болон түүнээс дээш настай өндөр настны 9 хувь), 3,775 эцэг, эхийнхээ аль нэгээс эсвэл аль алинаас тусгаарлагдсан хүүхэд (18-аас доош насны хүүхдүүдийн 3 хувь) судалгаа хийсэн хугацаанд бүртгэгдсэн байна. Түүнчлэн 4,243 өрх толгойлсон эцэг, эхтэй өрх, 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй¹ 10,637 өрх байгаа нь тус дүүргийн нийт өрхийн 4 хувь болон 11 хувийг тус тус эзэлж байна.

Сонгинохайрхан дүүрэг нь нийт 43 хороо, 387 хэсэгтэй. 33 дугаар хороо хамгийн их хүн амтай буюу дүүргийн хүн амын 5 хувийг эзэлж байгаа бол үүний дараа 22, 37 болон 19 дүгээр хороод нийт хүн амын 4 хувийг тус бүр эзэлж байна.

График 2. Хүн ам зүй, хороогоор (эзлэх хувь)



1.2 БҮРТГЭЛ


Судалгааг нэгтгэсэн хугацаанд нийт хэсгүүдийн 39 хувь нь иргэдийн 90 гаруй хувь нь оршин суугчийн бүртгэлтэй (шилжилт хөдөлгөөний бичиг баримтын зөрчилгүй) гэсэн тооцоо гаргасан ба үүний 6 хувь (22 хэсэгт) нь 100 хувь бүртгэлтэй байна. Түүнчлэн хэсгүүдийн 52 хувь нь дийлэнх иргэд нь бүртгэлтэй (иргэдийн 61-89 хувь), 7 хувь нь тал нь бүртгэлтэй (иргэдийн 40-60 хувь) гэсэн бол үлдсэн хэсгийн ердөө 2 хувь нь иргэдийн 40-с доош хувь бүртгүүлсэн гэж мэдээлжээ.

График 3. Албан ёсны бүртгэлээ хийлгэсэн байдал (эзлэх хувь)




¹ Өрхийн тэргүүн нь 60 ба түүнээс дээш насны хүнтэй өрх

График 4. Оршин суух бүртгэл 90-с дээш хувь хийгдсэн хороо (нийт хэсэг)



Иргэд өөрсдийгөө тухайн хэсэгт түр зуур оршин сууж байгаа гэж үзэн өөрийн оршин суугаа газартаа бүртгүүлэхгүй байгаа нь бүртгэлгүй байх үндсэн шалтгаан болж байна гэж тус дүүрэг дэх бүх хэсгийн 28 хувь мэдээлсэн. Энэ үзэгдэл ялангуяа 6 болон 33-р хороодод (тус бүрд 12 хэсгийн мэдээлснээр) зонхилон тохиолдсон харагдаж байна.

График 6. Бүртгэл хийлгэхгүй байгаа үндсэн шалтгаан (эзлэх хувь)




1.3 ИРСЭН ИРГЭД²

Тоон мэдээлэл нэгтгэхээс өмнөх сүүлийн зургаан сарын хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт нийт 7,214 иргэн ирсэн нь Улаанбаатар хотод ирсэн нийт иргэдийн 16 хувийг эзэлж байна. 18-р хороонд (дүүрэгт нийт ирэгсдийн 5 хувь) хамгийн өндөр хувьтай ирсэн иргэд бүртгэгдсэн гэж мэдээлсэн. Улаанбаатар хотын бусад дүүргээс ирэгсэд гуравны хоёр буюу 59 хувьтай зонхилж байгаа бол үүний дараа хөдөө орон нутгаас ирэгсэд (21 хувь), тус дүүргийн өөр хороо/хэсгээс ирсэн иргэд (20 хувь) байна.


² Ирсэн иргэд гэдэг нь тус дүүрэгт эсвэл дүүргээс гадна байршлаас ирсэн эсэхээс үл хамааран тус дүүрэг дэх аль нэг байршилд оршин суухаар ирсэн иргэн, айл өрхийг хэлнэ.

График 5. Оршин суух бүртгэл 10-с доош хувь хийгдсэн хороо (нийт хэсэг)



Бүртгүүлэхгүй байх бусад шалтгаанд боловсролын шалтгаан (16 хувь), бүртгүүлэхэд ямар ч ашиг тусыг олж харахгүй байна, бүртгэлийн маягтуудыг хэрхэн бөглөхийг мэдэхгүй (тус бүр 12 хувь), бүртгэлийн маягтыг бөглөхөд хэт төвөгтэй (9 хувь) гэсэн шалтгаанууд багтжээ.

График 7. Түр зуур оршин сууж байгаа гэж үзэн бүртгэл хийлгэдэггүй байгаа иргэдийн хамгийн өндөр үзүүлэлтэй 5 хороо (хэсгүүдийн эзлэх хувь)




Улаанбаатар хотын бусад дүүргээс ирэгсдийн 62 хувь нь гэр хороолол зонхилсон хэсгүүдээс ирсэн бол 28 хувь нь орон сууц зонхилсон хэсгүүдээс, 10 хувь нь орон сууц, гэр хороолол холимог хэсгүүдээс ирсэн байна.³ Хөдөө орон нутгаас ирсэн иргэдийн 49 хувь нь сумын төвийн багуудаас ирсэн бол 37 хувь нь аймгийн төвийн багуудаас, 15 хувь нь хөдөөгийн багуудаас⁴ ирсэн байна.

³ Гэр хороолол зонхилсон хэсэг гэдэг нь хот төлөвлөлтийн дэд бүтэц болон усны хангамжгүй Монголын уламжлалт амьдрах байрыг хэлнэ. Гэр хороолол зонхилсон хэсгийн оршин суугчид ихэвчлэн зөөврийн ус ашигаж мод эсвэл нүүрс түлж халаалтаа авдаг. Орон сууц зонхилсон хэсэгт улсаас халаалт болон ус хангамжийг шийдэж өгсөн байдаг. Гэр хороолол ба орон сууц холимог хэсэгт эдгээр хоёр амьдрах орчин нь хамтран оршдог.

⁴ Баг гэдэг нь хөдөө орон нутаг дахь засаг захиргааны хамгийн жижиг нэгж юм. Аймгийн төвийн баг гэдэг нь аймгийн төвд байрладаг засаг захиргааны хамгийн жижиг нэгж бол сумын төвийн баг гэж Монгол Улсын хөдөө орон нутгийн засаг захиргааны хамгийн жижиг хоёр дахь нэгжийг хэлнэ.


График 8. Ирсэн хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн 5 хороод (эзлэх хувь)




Бүдүүвч 1. Ирсэн хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)



Бүдүүвч 2. Улаанбаатар хот доторх ирсэн хөдөлгөөний төрөл (орон байрны төрөл)



Бүдүүвч 3. Хөдөө орон нутгаас ирсэн хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)




Тоон мэдээлэл нэгтгэх үед буюу 2022 оны 9 дүгээр сараас 2023 оны 2 дугаар саруудад Сонгинохайрхан дүүрэгт ердөө 16 иргэн отор нүүдэл⁵ хийх зорилгоор ирсэн байна. Энэ хөдөлгөөн дөрвөн хороонд бүртгэгдсэн ба 33-р хороонд оторлох

зорилгоор хамгийн их иргэд ирсэн байна (69 хувь). Оторлох зорилгоор ирсэн иргэд улирлын чанартай хөдөлгөөнд оролцох гэсэн үндсэн шалтгаанаар ирснийг энэ хөдөлгөөнийг бүртгэсэн хороодын тал буюу 56 хувь нь мэдээлжээ.

Бүдүүвч 3. Отор нүүдлийн үндсэн шалтгаан (эзлэх хувь)




График 9. Оторлох зорилгоор хамгийн олон иргэд ирсэн хороод (дүүрэгт эзлэх хувь)



⁵ Отор нь хол газар удаан хугацаагаар малаа маллан нүүдэллэхийг хэлнэ.


Сонгинохайрхан дүүрэгт отор нүүдэл хийхээс өөр шалтгаанаар ирэгсдийн хувьд боловсрол (22 хувийн мэдээлснээр) үндсэн шалтгаан хэвээр байгаа нь хоёр дугаар ээлжийн тоон мэдээлэл нэгтгэлийн үр дүнтэй адил байна. Түүнчлэн хөдөлмөр эрхлэх (20 хувь) гэсэн шалтгаан нь тус дүүрэгт ирэх хоёр дахь зонхилох шалтгаан болжээ. Сонгинохайрхан дүүрэгт хөдөлмөр эрхлэх зорилгоор ирэгсдийн

График 10. Отор нүүдлийн бус шилжилт хөдөлгөөнд оролцох болсон үндсэн шалтгаан (эзлэх хувь)



хувьд хөдөлмөр эрхлэлтийн зонхилох салбар нь барилга (30 хувь) болон нийгмийн ажлын салбар (19 хувь) байсан. Түүнчлэн тус дүүрэгт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэсэн шалтгаанаар ирэгсдийн үзүүлэлт өмнөх үнэлгээний үр дүнтэй харьцуулбал 11 хувиас 18 хувь хүрч өссөн бол орон сууц, газар эзэмших гэсэн шалтгаан 11 хувиас 17 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.

График 11. Хөдөлмөр эрхлэх үндсэн шалтгаанаар ирэгсдийн хөдөлмөр эрхлэлтийн үндэс салбарууд (эзлэх хувь)




1.4 ЯВСАН ИРГЭД⁶


Тоон мэдээлэл нэгтгэх судалгааны гурав дугаар үе шат эхлэхээс өмнөх зургаан сарын хугацаанд Сонгинохайрхан дүүргээс нийт 5,095 иргэн явсан гэж бүртгэгдсэн ба энэ үзүүлэлт нь Улаанбаатар хотоос явсан нийт иргэдийн 20 хувийг эзэлж байна. Явсан иргэдийн хамгийн өндөр хувийг 29-р хороо (дүүргийн нийт явсан иргэдийн 7 хувь) эзэлжээ. Улаанбаатар хотын бусад дүүрэг руу явсан иргэдийн үзүүлэлт (80 хувь) өндөр байгаа бол дүүрэг дотроо бусад хороо/хэсэг рүү (16 хувь), хөдөө орон нутаг руу (4 хувь) явсан хөдөлгөөн мөн бүртгэгдсэн байна.

Улаанбаатар хот дотроо шилжин явагсдын 47 хувь нь орон сууц зонхилсон хэсгүүд рүү нүүсэн бол 37 хувь гэр хороолол зонхилсон хэсгүүд рүү, 15 хувь нь орон сууц болон гэр хороолол холимог хэсгүүд рүү нүүсэн байна. Түүнчлэн хөдөө орон нутгийг зорьсон иргэдийн дийлэнх буюу 60 хувь нь аймгийн төвийн багууд руу явсан бол үлдсэн 30 хувь нь сумын төвийн багууд руу, 10 хувь нь хөдөөгийн багууд руу явсан байна.

График 12. Явсан хөдөлгөөн хамгийн их бүртгэгдсэн хороод (эзлэх хувь)




Бүдүүвч 4. Явсан хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)




⁶ Явсан иргэд гэдэг нь Улаанбаатар хотын аль байршилыг орхиж явснаас үл хамааран хотын нэг цэгээс нөгөө цэг рүү, эсвэл орон нутаг, гадаад улс оронд явсан иргэд, айл өрхийг хэлнэ. Мөн түүнчлэн энэхүү тоон мэдээлэл нь хэсгийн ахлагчийн мэдлэг, тандалт судалгаан дээр үндэслэн тооцоолсон тоо тул бодит тоон мэдээллээс зөрүүтэй байх боломжтой юм.

Бүдүүвч 6. Улаанбаатар хот доторх явсан хөдөлгөөний төрөл (орон байрны төрөл)




Бүдүүвч 5. Хөдөө орон нутаг руу явсан хөдөлгөөний төрөл (эзлэх хувь)




Сонгинохайрхан дүүргээс явсан иргэдийн үндсэн шалтгаан нь өмнөх судалгааны үр дүнтэй адил байна. Хөдөлмөр эрхлэлт нь өмнөх үнэлгээний 17 хувь гэсэн үзүүлэлтээс 23 хувь хүрч дүүргээс явах зонхилох шалтгаан болсон байна. Түүнчлэн, тоон мэдээлэл нэгтгэхээс өмнөх сүүлийн зургаан сарын хугацаанд үйлчилгээний хүртээмж илүү чухал шалтгаан болсныг 13 хувь гэсэн үзүүлэлт харуулж байна. Харин өмнө нь 11 хувь байсан гэр бүлтэйгээ нэгдэх гэсэн шалтгаан энэ удаагийн үнэлгээгээр үндсэн шалтгаан болоогүй байна.

График 12. Явсан хөдөлгөөний үндсэн шалтгаан (эзлэх хувь)



1.5 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

График 14. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбарууд (эзлэх хувь)



Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд хэсгүүдийн 36 хувийн мэдээлснээр барилгын салбар хөдөлмөр эрхлэлтийн зонхилох салбар байв. Нийгмийн ажлын

салбар өмнөх үнэлгээгээр ердөө 1 хувь байсан бол энэ удаа зонхилох хоёр дугаар салбар болж хэсгүүдийн 29 хувьд зонхилж байна.

1.6 САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Сонгинохайрхан дүүргийн орлогын үндсэн эх үүсвэр нь хөдөлмөр эрхлэлт гэж мэдээлсэн ба энэ үзүүлэлт хэсгүүдийн 87 хувьд зонхилж байна. Түүнчлэн ББСБ болон банкнаас авсан зээл болон тэтгэврийг орлогын үндсэн эх үүсвэр гэж хэсгүүдийн тус бүр 5 хувь нэрлэсэн байна.

Сүүлийн зургаан сарын хугацаанд хүнсний хэрэглээ мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан гэж хэсгүүдийн 85 хувь мэдээлжээ (өмнөх үнэлгээний 82 хувь гэсэн

үзүүлэлтээс бага зэрэг өссөн). Түүнчлэн 59 хэсэгт (хэсгүүдийн 15 хувь) хүнсний хэрэглээ тогтмол байдлаар буурсан үзүүлэлттэй байсан ба энэ нь 55,000 иргэнд (дүүргийн хүн амын 15 хувь) хүрч нөлөөлсөн гэж үзэж байна. 20 болон 35 дугаар хороонд (тус бүр 6 хэсэг) энэ үзүүлэлт хамгийн өндөр гарсан бол дараа нь 33 дүгээр хороо (5 хэсэг) өндөр үзүүлэлттэй байна.

График 15. Орлогын үндсэн эх үүсвэр (эзлэх хувь)




График 16. Хүнсний хэрэглээгээ багасгасан (эзлэх хувь)



Хүснэгт 1. Хүнсний хэрэглээгээ тогтмол байдлаар бууруулсан хамгийн олон өрхтэй хороод

Нийт 59 хэсэг	20-р хороо 6 хэсэг	35-р хороо 6 хэсэг	33-р хороо 5 хэсэг
1-р хороо 4 хэсэг	21-р хороо 4 хэсэг		30-р хороо 4 хэсэг

1.7 ШИЖИЛТ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБООТОЙ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд нийт хэсгүүдийн дөрөвний гурваас илүү буюу хэсгүүдийн 78 хувь тус дүүрэгт шилжин ирж буй иргэдийн нөлөөлөөс улбаатай хамгийн ихээр тулгамдаж буй багадаа нэг төрлийн асуудал байгаа гэж мэдээлсэн байна. 104,000 иргэнд (дүүргийн нийт хүн амын 30 хувь) хүрч нөлөөлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ачаалал өмнөх судалгааны 16 хувь гэсэн үзүүлэлтээс 23 хувь болсон нь хамгийн ихээр тулгамдаж буй асуудал хэвээр байгааг харуулж байна. Боловсролын үйлчилгээний ачааллыг хэсгүүдийн 21 хувь (өмнөх үнэлгээгээр 26 хувь байсан) мэдээлсэн ба энэ нь 105,000 иргэнд хүрч нөлөөлж байна. Түүнчлэн агаарын бохирдол (18 хувь) болон хүрээлэн буй орчны бохирдол (17 хувь) нэрлэсэн асуудлууд богино хугацааны шилжилт хөдөлгөөнөөс улбаатай зонхилох асуудлаар бүртгэгджээ.

Бүдүүвч 1. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлуудыг мэдээлсэн хэсгүүд (эзлэх хувь)




График 16. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд (эзлэх хувь)



Хүснэгт 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ачааллыг тулгамдсан асуудал болж байгаа талаар хамгийн ихээр мэдээлсэн хороод

Нийт 114 хэсэг	22-р хороо 12 хэсэг	33-р хороо 8 хэсэг
11-р хороо 6 хэсэг	29-р хороо 5 хэсэг	42-р хороо 5 хэсэг

Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд нийт хэсгүүдийн 89 хувь нь засаг захиргааны нэгжээс шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч ажилласан гэж мэдээлсэн бол 11 хувь нь хангалттай арга хэмжээ авч ажиллаагүй гэж мэдээлжээ. Засаг захиргаанаас одоогийн байдлаар авч хэрэгжүүлж

буй арга хэмжээнүүдээс гадна богино хугацааны хөдөлгөөнийг бүртгэх эрх зүйн орчныг сайжруулах, төвлөрсөн бүсийн орох, гарах хөдөлгөөний хяналтыг сайжруулах (22 хувь) асуудлыг эрх баригчид анхаарах нь зүйтэй гэж үндсэн мэдээлэгчдийн талаас илүү буюу 51 хувь үзсэн байна.

Бүдүүвч 9. Засаг захиргааны нэгжээс арга хэмжээ авч байгаа эсэх (эзлэх хувь)




График 18. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжтой бусад арга хэмжээ (хэсгийн хувь)




1.8 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ БА ДЭД БҮТЭЦ

Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд иргэдэд хамгийн хүртээмжгүй байгаа дэд бүтцээр орлогоо нэмэгдүүлэх боломж бололцооны дутмаг байдлыг нэрлэсэн хэсгүүдийн хувь өмнөх үнэлгээгээр 16 хувь байсан бол энэ удаагийн үнэлгээгээр 21 хувь хүрч өссөн байна. Түүнчлэн тулгамдаж буй бусад асуудалд

эрүүл мэндийн үйлчилгээний ачаалал (хэсгүүдийн 14 хувийн мэдээлснээр), боловсролын үйлчилгээний ачаалал (10 хувь) болон машины зогсоол (10 хувь) орсон ба энэ үр дүнг хоёр дугаар ээлжийн тоон мэдээлэл нэгтгэлийн үр дүнтэй харьцуулж үзэх нь зүйтэй.

График 19. Иргэдэд хүртээмжгүй байгаа үндсэн үйлчилгээ болон дэд бүтэц (эзлэх хувь)



Хүснэгт 3. Орлогоо нэмэгдүүлэх боломж бололцооны дутмаг байдал хамгийн их бүртгэгдсэн хороод

Нийт	6-р хороо	2-р хороо
176 хэсэг	11 хэсэг	9 хэсэг
8-р хороо	11-р хороо	24-р хороо
9 хэсэг	9 хэсэг	9 хэсэг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй үндсэн бэрхшээлээр нийтийн эзэмшлийн зам, талбай, барилга байгууламжид аюулгүй нэвтрэхэд шаардлагатай дэд бүтцийн дутмаг (33 хувийн

мэдээлснээр) байдлыг нэрлэсэн бол үүний араас тусгайлан тээврийн үйлчилгээний дутмаг байдал (25 хувь) тусгайлан эмнэлгийн тусламж үйлчилгээний дутмаг байдал (23 хувь) орсон байна.

График 20. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудлууд (эзлэх хувь)



ДҮГНЭЛТ

Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд хийсэн энэ удаагийн үнэлгээний үндсэн үзүүлэлтээс харвал эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ачаалал нэрлэсэн асуудал нь өмнөх удаагийн үнэлгээнээс хойш нэмэгдсэн байна. Энэ нь шилжилт хөдөлгөөний төлөв байдалд нөлөөлөх магадлал өндөр юм. Түүнчлэн энэ удаагийн үнэлгээний тоон мэдээллээс харвал дүүргээс явах үндсэн шалтгаанд үйлчилгээний хүртээмж, үүнд нэн ялангуяа эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ачаалал нэрлэсэн шалтгаан нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хангалтгүй байх нь эрүүл мэнд муудах, нийгмийн нягтрал буурах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Тиймээс уг бэрхшээлийн шалтгаан болон түүний шилжин суурьшигчийн сайн сайхан байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг дэлгэрэнгүй судалж үзэх нь зүйтэй.

Орлогоо нэмэгдүүлэх боломж бололцоо дутмаг байх асуудал нь хоёр дахь удаагийн тоон мэдээлэл нэгтгэлийн үр дүнтэй адил энэ удаа ч мөн үндсэн асуудлын нэг хэвээр байна. Уг асуудал нь хүнсний аюулгүй байдалд мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл үзүүлж байгааг энэ удаагийн үнэлгээний тоон мэдээлэл харуулж байна. Хэсгүүдийн 85 хувь нь хүнсний хэрэглээгээ тогтмол байдлаар бууруулсан ба энэ үзүүлэлт өмнөх үнэлгээнээс хойш өссөн байна.

Боловсролын үйлчилгээний ачаалал, боловсролын барилга байгууламжийн хомсдол нь Сонгинохайрхан дүүрэгт тулгамдаж буй бас нэгэн тулгамдсан асуудал бөгөөд дүүрэгт ирэх, дүүргээс явах хөдөлгөөний үндсэн шалтгаан болж байна. Боловсролын үйлчилгээний хязгаарлагдмал байдал ба түүний шилжилт хөдөлгөөний төлөв байдалд үзүүлэх нөлөөллийн уялдаа холбоог ойлгох нь шилжилт хөдөлгөөнтэй холбоотой бодлого боловсруулахад тулгарч буй сорилтуудыг тодорхойлоход нэн чухал юм.




© Жавхлантөгс

Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийн агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн туршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх, шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн сайхныг дээдлэх зэрэг зорилтын хүрээнд хамтран ажилладаг.

Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томъёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Тайланг загварчлах ажлыг Ямэй Дү, дотоодын зөвлөх Ганбатын Гэрэлтогтохын хамт боловсруулсан болно. Судалгааны асуулгын загварчлалыг ОУШХБ-ын ДТМ-ын баг, НЗДТГ-ын оролцоотойгоор боловсруулсан байна. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ийг дэмжих багийн техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.



Swiss Agency for Development and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг